



ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ

IDA credit-P174116

Телевизийн суваг болон мэдээний сайтуудаар төслийн үр дүн, хэрэгжилтийг мэдээлсэн ярилцлага, нэвтрүүлэг хийх, түгээх ажлын даалгавар

(СЗ-NC-2023-21-1)

Сонгогдсон хэвлэл мэдээллийн байгууллага, студио нь ОБҮДХЭТ-ийн хэрэгжих хугацаанд оролцогч талуудын тухай мэдээ, мэдээлэл, сурвалжлага бэлтгэн олон нийтэд түгээнэ. Гэрээний нийт үнэ 44,999 мянган төгрөгөөс дээшгүй байна.

Гүйцэтгэх ажлын агуулга:

Төслийн хэрэгжилтийн удирдамж, зааварчилгаа

- Бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах удирдамж видео
- Байгаль орчин, аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж видео

Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээ, үр дүнгийн талаарх видео, мэдээ мэдээлэл

- ХХҮЕГ-т хийсэн засварын ажлын танилцуулга богино видео /англи хэл, монгол хэл/
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтын видео
- eJob платформын видео танилцуулга

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх видео сурвалжлага, мэдээ мэдээлэл

- Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээний үр дүн видео, мэдээ мэдээлэл /монгол хэл, англи хэл, дохионы хэлний орчуулгатай/
- Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээлд хамрагдсан иргэдтэй хийсэн цуврал видео ярилцлага /бичвэр мэдээ мэдээлэл/

Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөрийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх видео сурвалжлага, мэдээ мэдээлэл

- Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөрийн үр дүнгийн танилцуулга видео /монгол хэл, англи хэл, дохионы хэлний орчуулгатай/
- Ур чадварын болон мэргэшүүлэх сургалтад хамрагдсан иргэдтэй хийсэн цуврал видео ярилцлага /бичвэр мэдээ мэдээлэл/

Төслийн үр дүн, судалгааны талаарх видео сурвалжлага, мэдээ мэдээлэл

- Төслийн хүрээнд хийгдсэн Ур чадварын эрэлтийн судалгааны талаар ХНХСҮСИ-тэй хийсэн видео ярилцлага /англи хэл, монгол хэл/
- Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөрийн нөлөөллийн үнэлгээний танилцуулга видео /монгол хэл, англи хэл/
- Олон нийтэд чиглэсэн ХЗЗ-ийн мэдээллийн порталын танилцуулга видео\

Сонгогдсон мэдээллийн агентлаг нь видео сурвалжлага, мэдээ, мэдээлэл бүтээхдээ ОБҮДХЭТ-өөс өгсөн мэдээлэлд үндэслэн олон нийтэд телевизийн суваг болон бусад зорилтот бүлгийн үзэгчдийн сонирхлыг татахуйц видео зохиол болон хар зургийг видео тус бүр дээр гаргана. Видеонууд нь анимэйшн, график, дүрс хосолсон хэлбэртэй байна.

Нийлүүлэх бүтээгдэхүүн

1. HD-1080, AVI формат бүхий видео бичлэгүүд;
2. Монтаж хийгдээгүй зураг авалтын эх дүрсүүд;
3. Гэрээт ажил гүйцэтгэсэн тухай эцсийн тайлан;

Оюуны өмч болон нууцлал

Уг ажилд холбогдох видео, аудио, цаасан хэлбэрийн материалууд нь ХНХЯ-ны оюуны өмчид хамаарна. Гүйцэтгэгч байгууллага нь видео танилцуулга бүтээхэд зориулагдсан бүхий л төрлийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр олон нийтэд хэсэгчлэн болон бүхлээр нь тараахгүй байх үүрэгтэй.

Тавигдах шаардлага

- Албан ёсны гэрчилгээ бүхий хуулийн этгээд байна.
- Видео танилцуулга, баримтат киноны чиглэлээр 3-аас дээш жил ажилласан туршлагатай найруулагч/редактор, зураглаач, график дизайнер бүхий мэргэжлийн багтай байх,
- Олон нийтэд зориулсан нэвтрүүлэг хийж байсан мэргэжлийн багтай байх,
- Олон нийт болон зорилтот бүлгүүдэд чиглэсэн богино хэмжээний видео, нэвтрүүлэг хийж байсан туршлагатай,
- HD форматын мэргэжлийн тоног төхөөрөмжтэй,
- Албан ёсны байршил, хаяг, утасны дугаар, и-мэйл-тэй,
- Өргөн сэдвийн хүрээнд богино хугацаанд чанартай бүтээл хийж байсан туршлагатай.

Явцын тайлан, үр дүнг хянах

Гэрээлэгч нь дээр дурдсан ажлыг ОБҮДХЭТ-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хяналт дор гүйцэтгэнэ. Студийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Үүнд:

- Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;
- Төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал;
- Гүйцэтгэсэн ажлын чанар;

Гэрээний хугацаа

Гэрээ байгуулагдсан өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл байна.

Төлбөр

Гэрээний төлбөрийн хуваарь 30% урьдчилгаа, ажлын даалгаварт тусгагдсан гүйцэтгэл тавин хувьд хүрч, явцын тайлан ба гүйцэтгэлийг хүлээн авсны дараа 30%, бүх ажлыг хүлээн авч, ажил хүлээлцэх акт үйлдэж үлдэгдэл 40% олгоно.

Бусад зохицуулалт

ОБҮДХЭТ-ийн зүгээс ямарваа нэгэн техник, тоног төхөөрөмж худалдан авч хангалт хийхгүй. Видео бүтээхэд шаардагдах тоног төхөөрөмжийг тухайн байгууллага студи өөрөө хариуцна. Зураг авалтын үеийн унааг өөрсдөө хариуцана.

Сонгон шалгаруулалтад орох хүсэлтэй байгууллага нь тавигдах шаардлагыг хангаж буйг илэрхийлэх баримт бичгүүдийг уг ажлыг хариуцан гүйцэтгэхэд оролцох ажилтнуудын анкет, өмнө хийж байсан бүтээлийн мэдээлэл, тус ажлыг гүйцэтгэх үнийн саналын хамт procurement@mesp.mn цахим хаягаар болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо 14200, Ерөнхий Сайд Амарын гудамж 29, Бага тойруу, Сан Бизнес центр, 501 тоотод ирүүлнэ үү.

Холбогдох утас: 75057570

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ